



**МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/520

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Буянт суманд хэрэгжүүлж буй Агро парк төслийн хүрээнд усалгааны зориулалт бүхий гүний худаг гаргасан “Топ дриллинг” ХХК -ийн хийж гүйцэтгэсэн ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Ш.Батжаргал - “Шинэ ховд хөгжлийн корпорац” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Гишүүд: Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Галбадрах - “Ховд агро парк” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Ц.Пүрэвсүрэн - Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Уянгамаа - “Шинэ ховд баруун бүсийн хөгжлийн корпорац”- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч

Э.Гансүх - Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлчээр усан хангамж хариуцсан мэргэжилтэн

Б.Түвшинсайхан - Буянт сумын Засаг дарга

8400 01 2605
Zah A/520 tum


Б.Сонинтуяа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Наранбаатар - "Шинэ ховд баруун бүсийн хөгжлийн корпорац"- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын мэргэжилтэн

2. Инженерийн хийцтэй гүний худгийн ажлыг хүлээн авахдаа холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3.Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн дарга (Ш.Батжаргал)-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ ДЭЛГЭРСАЙХАН